



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/347

Эрдэнэт

**Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын
бэлтгэл хангах арга хэмжээний тухай**

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3/a/, 29.2, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 23 дугаар тогтоол, Үндсэн чиглэл батлах тухай 2016 оны II тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны Ээлжит Ү хуралдааны 5/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хэмжээнд мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг зохион байгуулах, хяналт тавих Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг I, 2017-2018 оны бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг II, шаардагдах шатахууны зардлыг III хавсралтаар тус тус баталсугай.

2. Бэлтгэл ажлыг зохион байгуулах, хяналт тавин шалгаж, хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүний шатахууны зардалд шаардагдах 8000000 /Найман сая/ төгрөгийг /Малын өвөлжилт, хаваржилтыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах/ зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг эртнээс чанартай зохион байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Баян-Өндөр сумын Засаг дарга С.Ганцогт, Жаргалант сумын Засаг дарга Б.Зоригтбаяр, хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар ханган үр дүнг тооцож ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/, Онцгой байдлын газар /н.Ганбаатар/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч С.Батжаргалд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын
 22 өдрийн 847 дугаар захирамжийн III хавсралт

МАЛ АЖ АХУЙН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГУУЛАХ,
 ШАЛГАЖ ХҮЛЭЭН АВАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Явах газрын чиглэлийн нэр	Нэг удаа явах км	нийт явах тоо	Бүгд явах /км/	100 кг-т зарцуулах шатахуун /л/	нийт шатахууны хэмжээ /л/	1 литр шатахууны үнэ/төг/	нийт үнэ /төг/
1	Баянцагаан 4-р подъём	150	3	450	20	90	1580	142,200
2	Зүйл, Халиун, тариа бригад	200	3	600	20	120	1580	189,600
3	Залуугийн өвөр, Мааньт, Бухын даваа	300	3	900	20	180	1580	284,400
4	Ханхар цоохор морьт нарийн улаан хунх	300	3	900	20	180	1580	284,400
5	Хонгор овоо	250	3	750	20	150	1580	237,000
6	Нарангаас Хангалын гол	300	3	900	20	180	1580	284,400
7	Арцат	250	3	750	20	150	1580	237,000
8	Намаржааны гозгор	300	3	900	20	180	1580	284,400
9	Дарштаас Хангалын голын урдуур Орхоны зах хүртэл	300	3	900	20	180	1580	284,400
	Дүн	2350	3	7050	20	1410	1580	2,227,800
10	Аймгийн нөөцийн хадлан бэлтгэх газрыг үзэх гэрээ байгуулах	850	5	4250	20	850	1580	1,348,200
11	Мал сүргийг паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах хяналт тавих	1000	4	4000	20	800	1580	1,264,000
12	Мал амьтны сэг зэмийг устгах, ариутгал халдваргүйжилтийг хийх	2000	5	10000	20	2000	1580	3,160,000
	Нийт дүн	6,200	8	25,300	20	5,060	1580	8,000,000